

10.1. Эцэг эхийн системд бүртгүүлэх

10.1. Эцэг эхийн системд бүртгүүлэх

1. <http://parent.esis.edu.mn/> вэб хуудас руу орно.

2. Эцэг эхийн систем гарч ирнэ.

3. Нэвтрэх цонхны доор байрлах ШИНЭ ХЭРЭГЛЭГЧ БҮРТГҮҮЛЭХ товч дээр дарж шинээр бүртгүүлэх цонх руу орно.

4. Талбаруудыг бөглөн, бүртгүүлэх товч дээр дарна.

а. **Имэйл хаяг:** Эцэг/эх өөрийн имэйл хаягаа оруулна. /Имэйл хаягаар баталгаажуулах код очих тул баталгаат имэйл хаягаа ашиглах/

б. **Зурган текст:** Оруулах талбарын дээр байрлах ногоон дэвсгэр дээр байгаа зурган текстийг давтан

оруулах ёстой.

5.Бүртгүүлсэн имэйл хаягт системийн хэрэглэгчийн бүртгэлтэй холбоотой имэйл очсон байна.

а. **Хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код:** Тухайн кодыг хуулбарлан, хэрэглэгчийн бүртгэл баталгаажуулалтанд ашиглана.

6. Эцэг/эхийн системээс илгээсэн имэйл-н "**Энэ линкээр**" холбоосон дээр даран, хэрэглэгчийн бүртгэл баталгаажуулах рор-ур цонхыг дуудна.

а. **Нууц үг:** Эцэг/эх системийн эрхийн нууц үгийг оруулна.

б. **Нууц үг:** Эцэг/эх системийн эрхийн нууц давтан үгийг оруулна.

в. **Баталгаажуулах код:** Имэйл хаягаар илгээгдсэн баталгаажуулах кодыг давтан бичнэ.

г. **Зурган текст:** Оруулах талбарын дээр байрлах ногоон дэвсгэр дээр байгаа зурган текстийг давтан оруулах ёстой.

Дээрх талбаруудыг бүртгүүлсний дараа "**Баталгаажуулах**" товч даран, хэрэглэгчийн эрхийн бүртгэлийг баталгаажуулна.

7. Ингэснээр хэрэглэгчийн эрх баталгаажуулан, өөрийн имэйл хаяг болон нууц үгээ ашиглан <http://parent.esis.edu.mn/> вэб хуудас руу нэвтрэх боломжтой.

8. Эцэг эхийн системд нэвтрэх [10.2. Эцэг эхийн системд нэвтрэх](#) заавартай танилцана уу!

10.2. Эцэг эхийн системд нэвтрэх

10.2. Эцэг эхийн системд нэвтрэх

1. <http://parent.esis.edu.mn/> вэб хуудас руу орно.

2. Эцэг эхийн систем гарч ирнэ.

3. Нэвтрэх цонхны талбаруудад бүртгүүлсэн **имэйл хаяг** болон **нууц үгийг** бөглөн нэвтэрнэ.

Анхаарах зүйл:

Хэрвээ та системд бүртгүүлээгүй бол [10.1. Эцэг эхийн системд бүртгүүлэх](#) заавартай танилцана уу!

10.3. Эцэг/эхийн эрхтэй сурагчийг холбох хүсэлт илгээх

10.3. Эцэг/эхийн эрхтэй сурагчийн мэдээллийг холбох хүсэлт илгээх

Анхаарах зүйлс:

-Эцэг, эх, асран хамгаалагчид өөрийн хүүхдийн мэдээлэлд хандах эрх авахын тулд Анги удирдсан багш рүү хүүхэд холбох хүсэлт явуулна.

-Анги удирдсан багш тус хүүхэд холбох хүсэлтийг зөвшөөрч, цуцлах эрхтэй.

Хэрэглэгч өөрийн эрхээр <http://parent.esis.edu.mn/> вэб хуудас руу нэвтэрч орсны дараа өөрийн хүүхдийн мэдээллийг оруулан, сургууль руу хүүхэд холбох хүсэлт явуулна.

1. Хүүхэд холбох цэс рүү орж, **Нэмэх** товч дээр дарна.

2. Хүүхдийн мэдээлэл талбаруудыг үнэн зөв бөглөн, Сургуулийн мэдээлэл хэсэг рүү орно.

/Талбаруудыг үнэн зөв бөглөөгүй бол алдаа зааж, Сургуулийн мэдээлэл хэсэг рүү шилжих боломжгүй болно./

Анхаарах зүйлс:

-Тухайн нэг сурагчийн мэдээлэлд зөвхөн нэг эцэг, эхийн бүртгэлтэй эрхээр хандах боломжтой.

-Нэг эцэг, эхийн системийн эрхэнд олон сурагчийн мэдээллийг холбогдох боломжтой.

-Эцэг эхийн илгээсэн мэдээлэл нь системийн мэдээлэлтэй тохирсон тохиолдолд “Сурагчийн мэдээлэл холбох хүсэлт” амжилттай болно. /РД, ургийн овог, эцэг/эхийн нэр, нэр, хүйс, төрсөн огноо талбарууд/

-Мэдээллийг кирилл үсгээр, юникод фронт ашиглан, үнэн зөв бөглөнө.

1. Хүүхдийн мэдээлэл оруулах хэсэгт дараах талбаруудыг бөглөнө.

-Та хүүхдийн хэн болох

-Регистрийн дугаар

-Ургийн овог

-Эцэг/эхийн нэр

-Нэр

-Хүйс

-Төрсөн огноо

2. Сургуулийн мэдээлэл оруулах хэсэгт дараах талбаруудыг бөглөнө.

-Аймаг, нийслэл

-Сум, дүүрэг

-Сургууль, цэцэрлэг

-Боловсролын түвшийн

-Анги

-Бүлэг

-Анги удирдсан багшийн овог нэр

10.4. Эцэг/эхийн эрхтэй сурагч холбох хүсэлт шийдвэрлэх

10.4. Эцэг/эхийн эрхтэй сурагчийн мэдээлэл холбох хүсэлтийг шийдвэрлэх

Анхаарах зүйлс:

1. Эцэг, эх, асран хамгаалагчид өөрийн хүүхдийн мэдээлэлд хандах эрх авахын тулд Анги удирдсан багш рүү хүүхэд холбох хүсэлт явуулна.

2. Анги удирдсан багш тус хүүхэд холбох хүсэлтийг зөвшөөрч, цуцлах эрхтэй.

Суралцагчийн эрх Эцэг/эх үйл ажиллагаа идэвхжүүлэн сонгоход, тухайн АУБ-д ирсэн хүсэлтүүдийн жагсаалт харагдана.

Хүсэлтийн жагсаалтаас **Бүлэг, Суралцагчийн овог, нэр, Регистрийн дугаар, суралцагчийн төлөв, хүсэлт илгээгчийн овог, нэр, Регистрийн дугаар, хүсэлт илгээсэн огноо, хүсэлтийг шийдвэрлэсэн төлөв** зэрэг мэдээллүүдийг харах боломжтой.

Хүсэлтийн жагсаалтын ард байрдах "**Дэлгэрэнгүй**" товчин дээр даран, хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн цонхыг дуудна.

- Тухайн хүүхдийн мэдээллийг хүсэлт явуулсан эцэг, эхэд харуулахыг зөвшөөрөх

- Тухайн хүүхдийн мэдээллийг хүсэлт явуулсан эцэг, эхэд харуулахыг үл зөвшөөрөх

